



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 31 өдөр

Дугаар 67

Мандалговь

Балансаас балансад хөрөнгө
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн 18.1.3-ын "б", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1. Сайнцагаан сумын Цэгцбилиг сургуулийн үндсэн хөрөнгийн машин тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй 21 ширхэг компьютер, 100,000 төгрөгийн нэг бүрийн үнэтэй, 2,100,000 төгрөгийн нийт өртөгтэй хөрөнгийг Адаацаг сумын сургуульд балансаас балансанд шилжүүлэхийг сургуулийн ня-бо (П.Мөнгөнцэцэг)-т зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийн бүрэн бүтэн байдал, холбогдох бичиг баримтын бүрдлийг хангаж хүлээлцэхийг тус сургуулийн нярав (Ц.Лхагва-Очир)-т даалгасугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Цэгцбилиг сургуулийн захирал (Б.Түвшин-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Т.БАТЖАРГАЛ